Төгсөгчдийн талаарх ажил олгогчийн сэтгэл ханамжийн судалгаа

Д.Даваачимэг[1], Д.Сансармаа[1], Ч.Баярзориг[2], Д.Янсанжав[2], Г.Энхцэцэг[2], Н.Дашзэвэг[2], Л.Янжинсүрэн[2], Б.Хостуяа[2], Ц.Ундрах[2]

[1,2]АШУҮИС-ийн Дорноговь аймаг дахь салбар АУС
Цахим хаяг: davaachimeg@mnums.edu.mn, Утас: 88856405

Түлхүүр үг

Ажил олгогч
Сэтгэл ханамж
Төгсөгч үнэлэх

Товч утга:

Үндэслэл: Ажил олгогчийн сэтгэл ханамжийг тодорхойлж, бэлтгэгдэж буй мэргэжилтний ур чадвар хөдөлмөрийн зах зээлд нийцэж буй эсэх, төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтэд дутагдаж буй ерөнхий ур чадварыг үнэлүүлэх, ажил олгогчдын үнэлгээ, хүлээлтэд тулгуурлан сургалтын чанар хүртээмжийг нэмэгдүүлэхэд зорилгоор тухайн судалгааг хийсэн болно. **Зорилго:** Төгсөгчдийг үнэлсэн сонирхогч талуудын сэтгэл ханамжийн түвшинг тодорхойлох. **Материал арга зүй:** Бүсийн аймгуудын ажил олгогчийн сэтгэл ханамжийн судалгааны мэдээллийг цуглуулахдаа нүүр тулсан сурвалжилга /Face to face Interview/-ын аргыг ашигласан бөгөөд нээлттэй мэдээллийг кодолсны үндсэн дээр SPSS 23.0 программ дээр боловсруулсан юм. **Үр дүн:** сургалтын үйл ажиллагааны талаар нийт судалгаанд хамрагдагсдын сэтгэл ханамжийн түвшингийн дээд утга 4.31, доод утга 3.79, дундаж утга 4.01 байгаа нь төгсөгчидтэй хамтран ажиллагч, ажил олгогч талын сэтгэл ханамж сайн байгааг харуулж байна. ЭМБ-ын удирдлагуудын 42.8 хувь нь нь сургалтын хөтөлбөрийг хангалттай, 43 хувь нь дунд зэрэг, 14.2 хувь нь нь хангалтгүй хэмээн үнэлсэн байна. **Дүгнэлт:** Сургалтын үйл ажиллагааны талаар нийт судалгаанд хамрагдагсан ажил олгогчдын сэтгэл ханамжийн түвшин 4.01 байгаа нь хамтран ажиллагч, ажил олгогч талын сэтгэл ханамж сайн байгааг харуулж байна. Чанарын судалгааны үр дүнгээс харахад эмнэлгийн тусгай мэргэжилтэн шаардлагатай байна. Оюутнуудад онолын мэдлэгийг сайн олгохоос гадна анхан шатны эмнэлгийн байгууллагад ажиллах чадварыг нэмэгдүүлэх, эмнэлгийн орчинд, хүнтэй харьцах дадлага сургалтыг түлхүү оруулах, төгсөгчдийн бичгийн соёл, зөв бичих тал дээр анхаарах, хувь хүний хөгжлийг дэмжсэн soft skills ур чадварыг хөгжүүлэх шаардлагатай байгаа нь харагдлаа.

Үндэслэл: Аливаа байгууллагын үнэт зүйлсийн тоонд чанар, сэтгэл ханамж багтдаг бөгөөд энэ үнэт зүйлийг үйлчлүүлэгчдээсээ олж авдаг. Хэнд, юуг, яагаад, хэрхэн хүргэж үйлчилж байна гэдгээс хамаарч сэтгэл ханамж тодорхойлогддог. Тиймээс өнөөгийн хөдөлмөрийн зах зээл дээр АШУҮИС-ийн Дорноговь аймаг дахь салбар АУС-ийг төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн ур чадварын байдал, ажил олгогчийн сэтгэл ханамжийг тодорхойлж, бэлтгэгдэж буй мэргэжилтний ур чадвар хөдөлмөрийн зах зээлд нийцэж буй эсэх, төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтэд дутагдаж буй ерөнхий ур чадварыг үнэлүүлэх, ажил олгогчдын үнэлгээ, хүлээлтэд тулгуурлан сургалтын чанар хүртээмжийг нэмэгдүүлэхэд зорилгоор тухайн судалгааг хийсэн болно.

Зорилго: Төгсөгчдийг үнэлсэн сонирхогч талуудын сэтгэл ханамжийн түвшинг тодорхойлох

Зорилт:

1. Бүсийн аймгуудын ажил олгогчдын сэтгэл ханамжийг урьдчилан бэлтгэсэн асуумжаар авч тодорхойлох
2. Ажил олгогчдоос чанарын судалгаа авч, үр дүнг нэгтгэх

Судалгааны материал арга, зүй: Судалгааг аналитик судалгааны нэг агшингийн загвараар хийж гүйцэтгэв. Зорилтот түүврийн аргаар Дорнод, Хэнтий, Сүхбаатар, Өмнөговь, Дундговь, Говьсүмбэр, Дорноговь зэрэг аймгуудын ажил олгогчийн сэтгэл ханамжийн судалгааны мэдээллийг цуглуулахдаа нүүр тулсан сурвалжилга /Face to face Interview/-ын аргыг ашигласан бөгөөд нээлттэй мэдээллийг кодолсны үндсэн дээр SPSS 23.0 программ дээр боловсруулсан юм.

Үр дүн: Судалгаанд оролцсон ажил олгогчид ажилтанг шинэ ажлын байранд авахдаа мэдээллийн хэрэгслээр дамжуулан авдаг. Мөн төгсөгчид төгсөлтийн өмнө дадлага хийх, төгсөгч өөрөө хандах байдлаар ажилд ордог нь тэдний ярилцлаганд дурьдагдсан байна. Багаар ажиллах, өөрийгөө хөгжүүлэх, цаг төлөвлах, цаг баримтлах, санаачлагатай байх, ажлын хэрэгцээний гадаад хэл, компьютер ашиглах чадвар эзэмшсэн байх нь ажилд орох давуу тал болдог гэсэн байна.

Хүснэгт 1. Судалгаанд хамрагдсан ЭМБ-ын удирдлагууд

№	Аймаг	Судалгаанд оролцогчдын тоо
1	Хэнтий	7
2	Сүхбаатар	5
3	Өмнөговь	4
4	Дорноговь	3
5	Дорнод	6
6	Дундговь	5
7	Говьсүмбэр	3
Нийт		33

Хүснэгт 2. Төгсөгчдийг үнэлсэн ЭМБ-ын удирдлагуудын үнэлгээ

Үзүүлэлт	Тоо	Дундаж	Дунджийн стандарт алдаа	Стандарт хэлбэлзэл	95% CI	
					Доод	Дээд
Сургалтанд өгөх үнэлгээ	33	3,88	0,116	0,661	3,64	4,19
Асуудал шийдвэрлэх чадвар	33	4,9	0,177	0,100	4,53	4,97
Мэргэжлийн мэдлэг	33	3,75	0,107	0,608	3,53	3,96
Мэргэжлийн чадвар	33	4,0	0,162	0,917	3,66	4,33
Өөрийгөө хөгжүүлэх чадвар	33	4,7	0,169	0,956	4,35	4,95
Харилцаа хандлага, ёс зүй	33	3,28	0,108	0,612	3,06	3,50
Дундаж	33	4,01	0,135	0, 773	3,79	4,31

Дээрх хүснэгтээс харахад сургалтын үйл ажиллагааны талаар нийт судалгаанд хамрагдагсдын сэтгэл ханамжийн түвшингийн дээд утга 4.31, доод утга 3.79, дундаж утга 4.01 байгаа нь төгсөгчидтэй хамтран ажиллагч, ажил олгогч талын сэтгэл ханамж сайн байгааг харуулж байна. ЭМБ-ын удирдлагуудын 42.8 хувь нь нь сургалтын хөтөлбөрийг хангалттай, 43 хувь нь дунд зэрэг, 14.2 хувь нь нь хангалтгүй хэмээн үнэлсэн байна.

Сэтгэл ханамж буурахад нөлөөлж буй хүчин зүйлсийг тодруулбал:

- Төгсөгчдийн ерөнхий мэдлэг, хувь хүний төлөвшил, soft skill ур чадвар
- Бичих чадвар
- ЭМ-ийн анхан шатны баримт бичиг, эмийн хуудас, тооцоо хөтлөх чадвар
- I шатлалын эмнэлэгт хийгдэх нийгмийн эрүүл мэндийн арга хэмжээнүүдийг гардан зохион байгуулах, өвчний тархвар зүйн чиглэлээр энгийн тандалт явуулж үнэлгээ, дүгнэлт гаргах
- Өвчлөл, эмгэгийн шалтгаан үүсвэрийг тодорхойлох үүднээс лабораторийн тусгай шинжилгээ зааж бичих

Чанарын судалгааны дүн: Зүүн бүсийн аймгуудын Эрүүл мэндийн байгууллагын хүний нөөцийн 70-80 орчим хувийг Дорноговь АУС-ийн төгсөгчид эзэлж байна. Эрүүл мэндийн байгууллагуудад төнөг төхөөрөмж, материал, технологийн шинэчлэлт тасралтгүй хийгдэж байна. Тухайлбал ихэнх хагалгаа дурангаар хийгдэж байна. Үүнийг дагаад эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер, мэргэжилтэн шаардлагатай болж байна. Их эмч мэргэжилтнээр ерөнхийдөө хангагдсан, харин сувилахуйн арга зүйч, НЭМ-ийн ажилтан, бага эмч, эх баригч, туслах сувилагч зэрэг мэргэжилтэн хэрэгцээтэй байна гэжээ. Зарим аймагт эх баригч мэргэжилтэн сүүлийн жилүүдэд огт ирэхгүй байгаа талаар мэдээллээ.

Ажил олгогчид бичгийн соёл, мэргэжилдээ дур сонирхолтой байдал, ёс зүй, харилцаа хандлага сайтай ажилтан авах сонирхолтой байгаа нь ажиглагдлаа. Мөн шинэ ажилтны тогтвор суурьшил, гэр бүлийн байдал зэргийг судлан, дадлагажуулж авдаг байна.

Зарим аймгуудын Эрүүл мэндийн байгууллагын удирдлагатай ярилцсан судалгааны дүнгээс дурьдвал: Өмнөговь аймаг: Манай аймгийн Эрүүл мэндийн салбарын гол ачааг үүрч байгаа хүмүүс бол Дорноговь салбар сургуулийн төгсөгчид байдаг. Тэд хөрвөх чадвартай, сэхээний тасаг, гэмтлийн тасаг, төрөх эмэгтэйчүүд гээд бүх л тасаг кабинетуудад манлайлан ажиллаж байна. Тухайлбал үе солих хагалгаа, тархины хагалгааг амжилттай хийж нутагшуулаад байна. Бусад сургуулийн төгсөгчдийг бодвол АШУҮИС болон танай төгсөгчид илүү чадварлаг, ажилдаа хурдан гаршиж мэргэшдэг. Мэргэжлээс гадна урлаг, спортын тал дээр ч сайн хөгжсөн байдаг.

Сүүлийн үед муляж дээр ажиллаж хүнтэй шууд харьцах нь багассан байна. Төгсөгчид хүний сэтгэл зүйтэй харьцах нь чухал, онол талдаа жаахан анхаарах хэрэгтэй. Цаашид харилцаа хандлагын сургалтыг түлхүү оруулах, эмнэл зүйн дадлагыг сайн

хийлгэн, хүнтэй ажиллуулах хэрэгтэй. Мөн туслах сувилагчийг ажлын байран дээр нь бэлтгэх боломж байдаг бол хамтран ажиллахад бэлэн байна. (Өмнөговь аймаг ЭМБУ)

Сүхбаатар аймаг: Төгсөгчдийн мэргэжлийн ур чадвар, хандлагын хувьд харилцан адилгүй байна. Төгсөгчдөөс сайн ажиллаж байгаа олон хүн бий. 2013-2014 оноос хойш төгсөгчдийн мэдлэг ур чадвар сул болж байгаа хандлага ажиглагдаж байна. Төгсөгчдийн хэл яриа болон ерөнхий бичгийн чадвар, жирэмсэн эхийг хянах, эмийн талаарх мэдлэг сул байна. Ерөнхийдөө сургалтын чанар, харилцаа хандлагыг сайжруулах нь чухал байна.

Хэнтий аймаг: Танай сургуулийн төгсөгчдийг ёс зүй, харилцаа хандлага, мэргэжлийн чадварын хувьд ажиллуулах хүсэлтэй байдаг. Хувь хүний төлөвшлөөс их хамаардаг байх, зарим нэг хүмүүс ажилдаа сэтгэлгүй хандах тал ажиглагддаг. Шинээр төгсөөд ажил дээр гарахад анхан шатны маягт бөглөх, эмнэлгийн санхүү, менежментийн талаарх асуудал тулгарч байна. Иймд төгсөх жил нь сургалтын хөтөлбөртөө өрх суманд ажиллахад эрүүл мэндийн менежмент болон яаралтай тусламжийн хичээлийг илүү түлхүү оруулж, тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх боломжоор ханган ажиллах нь чухал байна.

Дундговь аймаг: Төгсөгчдийн хувьд ерөнхий анагаахын мэдлэг дунд түвшинд байдаг. Резидент хийгээд, дараа нь төрөлжсөн хийгээд ирэхлээр чадварждаг. Чадварыг бол дадлагажуулаад авч болно. Харин суурь мэдлэг сайтай, зөв хандлагатай, ажилдаа чин үнэнчээр ханддаг, стандарт удирдамж бол бидний ажлыг хөтлөх гол зүйл гэсэн ойлголт суусан мэргэжилтэн хэрэгтэй байна.

Хэлцэмж: Монгол улсад боловсролын үйл ажиллагаа эрхэлдэг томоохон сургуулиудын (МУБИС, ШУТИС, Хүмүүнлэг, Шинэ анагаах ухаан, Ач Анагаахын сургууль) сургуулиудын 2018-2019 оны хичээлийн жилд хийсэн "Ажил олгогчдын сэтгэл ханамжийн судалгаа"-ны үр дүнтэй харьцуулж үзэхэд: Төгсөгчдийн өөрийгөө илэрхийлэх чадвар, зөв бичих, ажилдаа хандах байдал, харилцаа хандлага тааруу гэж ажил олгогчдын зүгээс өгсөн үнэлгээтэй манай судалгааны үр дүн ижил утгатай байна.

Дээрх судалгаанд төгсөгчдийн практик ур чадвар ихээхэн тааруу байдаг тул дахин сургах шаардлагатай гэж үзсэн бол бидний судалгаанд төгсөгчдийн хувьд практик ур чадвар сайн, харин онолын мэдлэг тааруу гэж үнэлсэн нь зөрүүтэй байна.

Бид хөдөлмөрийн зах зээлийн судалгааг хийж үр дүнг хөтөлбөрийн хэрэгжилтэнд тусган ажиллаж байна. Бидний 2017 онд хийсэн ажил олгогчдын сэтгэл ханамжийн судалгааны үр дүнтэй энэхүү судалгааны үр дүнг харьцуулахад өвчний түүх хөтлөлт, эмнэлгийн анхан шатны маягт хөтлөх чадвар, өгсөн үүрэг даалгаварыг гүйцэтгэх чадвар, харьцаа хандлага зэрэг үзүүлэлтэд өгсөн үнэлгээ харьцангүй сайжирсан байна. Харин онолын мэдлэг, цаг баримтлах, ажилдаа сэтгэлтэй хандах байдал, бичгийн соёл зэрэг үзүүлэлт дээр сэтгэл ханамж тааруу үнэлэгдсэн хэвээр байна.

МУБИС, ШУТИС, Хүмүүнлэг, Шинэ анагаах ухаан, Ач Анагаахын сургууль зэрэг сургуулийн "Ажил олгогч"-той хийсэн ярилцлагад: Шинээр төгсөгчид ажилд ороход чухам ямар чадварууд дутагдалтай буюу нэн шаардлагатай байгааг тодруулахад мэргэжлийн мэдлэг, ур чадвар, хувь хүний харилцаа хандлага (нийт ажил олгогчдын-26.7%) ихээхэн чухал гэж үзсэн нь манай судалгааны үр дүнтэй ойролцоо байна.

Дүгнэлт:

1. Судалгаанд хамрагдагсан зүүн болон говийн бүсийн аймгуудын ажил олгогчдын сэтгэл ханамжийн түвшин 4.01 байгаа нь хамтран ажиллагч, ажил олгогч талын сэтгэл ханамж сайн байгааг харуулж байна.
2. Дээд утга 4.31, доод утга 3.79, дундаж утга 4.01 байгаа нь төгсөгчидтэй хамтран ажиллагч, ажил олгогч талын сэтгэл ханамж сайн байгааг харуулж байна.
3. Чанарын судалгааны үр дүнгээс харахад бүс нутагт эмнэлгийн тусгай мэргэжилтэн шаардлагатай байна. Төгсөгчдөд онолын мэдлэгийг сайн олгохоос гадна эмнэлгийн орчинд дадлага хийлгэх, харилцааны ур чадварыг нэмэгдүүлэх, бичгийн соёл, хувь хүний хөгжлийг дэмжсэн soft skills ур чадварыг хөгжүүлэх, эмнэлгийн санхүү, менежментийн чиглэлийн сургалтууд шаардлагатай байгаа нь харагдлаа.

Employer satisfaction survey

Davaachimeg D[1], Sansarmaa D[1], Bayarzorig Ch[2], Yansanjav D[2], Enkhtsetseg G[2], Dashzeveg N[2], Yanjinsuren l[2], Khostuya B[2], Undrakh Ch[2]

[12]Dornogobi Medical School - a branch school of MNUMS
Email: davaachimeg@mnums.edu.mn, tel:88856405

Background: The survey provides information about the quality of education provided at Dornogobi Medical School - a branch school of MNUMS, by asking supervisors to provide feedback about the generic skills, technical skills and work readiness of the graduate employed in their workplace.
Purpose: Determine the level of stakeholder satisfaction that evaluates graduates. Materials and methods: Face-to-face interviews were used to collect employer satisfaction data from the aimags, which were encoded in SPSS 23.0.
Results: The highest level of satisfaction with the training activities was 4.31, the lowest value was 3.79, and the average value was 4.01, which indicates that the satisfaction of the alumni and employers is good. 42.8 percent of health facility managers rated the training program as adequate, 43 percent as moderate, and 14.2 percent as inadequate.
Conclusion: The level of satisfaction of employers surveyed about the training activities is 4.01, which indicates that the satisfaction of co-workers and employers is good.